



II/2022

Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14




Нас гүйцсэн эр хонины үнэ Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 300.0 мянган төгрөг байна

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 2 дугаар сард атны үнэ 1.4 сая төгрөг болж, өмнөх сараас 14.8 мянган төгрөг, соёолон үрээнийх 1.1 сая төгрөг болж, өмнөх сараас 18.9 мянган төгрөг, хязаалан гуных 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 22.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.


Эр хонины үнэ 213.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.4 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 154.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.3 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2022 оны 2 дугаар сард, мянган төгрөгөөр




Эр хонины үнэ 2022 оны 2 дугаар сард Улаанбаатар хотод хамгийн их буюу 300.0 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна. Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 175.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 2. НАС ГҮЙЦСЭН ЭР ХОНИНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 2 дугаар сард, мянган төгрөг




Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2022 оны 2 дугаар сард боодолтой өвсний (20 кг) үнэ Говь-Алтай аймагт хамгийн их буюу 11.1 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 2.9 мянган төгрөг байна.

ЗУРАГ 3. БООДОЛТОЙ ӨВСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 2 дугаар сард, төгрөгөөр



Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 2 дугаар сард 6.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.6 мянган төгрөгөөр буурсан байна. Харин ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 104.8 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.7 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 4. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 2 дугаар сард, төгрөгөөр



Хивэгний (25 кг) үнэ 2022 оны 2 дугаар сард Орхон аймагт хамгийн их буюу 25.0 мянган төгрөг, Архангай аймагт хамгийн бага буюу 14.2 мянган төгрөг байна.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
Үнийн статистикийн хэлтсийн гэрээт
ажилтан Б. Оргил
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212